

## МӨНГӨНИЙ ТОЙМ

2017 оны 2 дугаар сар

ХУРААНГУЙ:

- Мөнгөний нийлүүлэлт 3.2 хувиар өсч 12.3 их наяд төгрөг болжээ. Үүнд төгрөгийн хадгаламж 6.6 хувиар, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 31.5 хувиар өссөн нь гол нөлөө үзүүлэв.
- Сүүлийн 3 сар дараалан гадаад валютын хадгаламж буурч, төгрөгийн хадгаламж нэмэгдэж байна.
- Тайлант сард нөөц мөнгө 95.5 тэрбум төгрөгөөр буурч 2933.6 тэрбум төгрөг болжээ. Хэдийгээр банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж 112.8 тэрбум төгрөгөөр буурсан ч хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 158.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл 16.5 их наяд төгрөг болсон бөгөөд үүний 48.3 хувь иргэдэд, 44.4 хувь хувийн хэвшилд, 7.2 хувь нь улсын байгууллагуудад олгосон зээл байна.
- Санхүүгийн байгууллагуудын зээлийн 10.6 хувь нь хугацаа хэтэрсэн, 7.4 хувь нь чанаргүй гэж ангилагджээ.
- Мөнгө, зээлийн үзүүлэлтүүдээс харахад эдийн засгийн идэвхжил сул хэвээр байна.

## МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2016				2017		
	3-р сар	6-р сар	9-р сар	12-р сар	1-р сар	2-р сар	
<b>Инфляци</b>							
Улаанбаатар хотын	сарын	0.3	-0.5	-0.9	0.9	1.3	0.6
	оны эхнээс	1.5	2.7	0.1	0.5	1.3	1.9
	жиллийн	1.1	1.2	-0.7	0.5	1.4	1.2
Суурь	сарын	-0.4	-0.1	0.3	0.3	0.1	0.3
	оны эхнээс	-1.1	-1.2	-1.0	0.5	0.1	0.4
	жиллийн	3.1	3.0	0.8	0.5	1.0	1.7
Улсын	сарын	0.5	-0.3	-0.6	0.7	1.2	0.9
	оны эхнээс	1.7	2.9	0.6	1.1	1.2	2.1
	жиллийн	1.7	1.6	-0.1	1.1	1.9	2.1
<b>Мөнгө, санхүүгийн сектор</b>							
Нөөц мөнгө, сая ₮		2,422,256.5	3,584,981.9	3,164,886.1	3,487,656.0	2,838,102.5	2,933,570.6
сарын өөрчлөлт, хувиар		2.2	9.8	-4.8	-1.7	-7.4	3.4
жиллийн өөрчлөлт, хувиар		-4.9	47.5	27.1	38.4	22.8	27.1
M2 мөнгө, сая ₮		10,112,436.2	11,186,374.0	11,555,864.1	12,076,501.7	11,880,661.8	12,257,201.8
сарын өөрчлөлт, хувиар		1.0	5.0	1.6	3.0	-1.6	3.2
жиллийн өөрчлөлт, хувиар		2.1	11.4	16.3	20.2	20.6	22.4
Бусад хадгаламж, сая ₮		8,528,699.5	9,204,169.0	9,535,322.2	9,986,377.6	9,928,266.8	10,112,179.4
сарын өөрчлөлт, хувиар		0.5	3.3	1.5	1.9	-0.6	1.9
жиллийн өөрчлөлт, хувиар		0.9	9.9	14.6	19.4	20.5	19.1
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, сая ₮		658,588.9	839,237.9	795,795.9	823,629.3	736,068.2	944,705.5
сарын өөрчлөлт, хувиар		0.5	6.5	-2.6	7.1	-10.6	28.3
жиллийн өөрчлөлт, хувиар		-6.3	11.0	3.6	16.6	3.1	44.1
Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, сая ₮		18,430,337.9	18,410,238.6	19,240,122.0	16,449,122.3	16,367,469.2	16,518,521.1
сарын өөрчлөлт, хувиар		1.5	1.7	0.6	-16.7	-0.5	0.9
жиллийн өөрчлөлт, хувиар		11.5	8.1	8.0	-8.3	-9.4	-9.0
Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, сая ₮		11,835,465.1	12,030,355.9	12,490,873.6	12,422,235.9	12,379,495.2	12,583,529.0
сарын өөрчлөлт, хувиар		1.7	5.1	0.4	-2.3	-0.3	1.6
жиллийн өөрчлөлт, хувиар		-3.6	0.6	4.6	6.1	5.0	8.1
Хад. байгууллагуудын чанаргүй зээлийн үлдэгдэл, сая ₮		967,863.5	1,035,568.5	1,119,261.8	1,051,680.5	1,056,150.4	1,070,100.6
сарын өөрчлөлт, хувиар		6.2	-2.6	-0.6	-9.9	0.4	1.3
жиллийн өөрчлөлт, хувиар		37.7	33.8	31.3	20.9	18.1	17.5
Мөнгөний үржүүлэгч		4.2	3.1	3.4	4.0	4.2	4.2
<b>Хүү</b>							
Хадгаламжийн ЖДХ		13.3	13.3	13.2	13.1	13.4	13.3
Хадгаламжийн бодит хүү*		12.2	12.1	13.8	12.6	12.0	12.1
Зээлийн ЖДХ**		19.7	19.1	20.1	19.7	20.2	20.1
Зээлийн бодит хүү*		18.6	18.0	20.8	19.2	18.8	18.9
Ипотекийн зээлийн хүү		8.8	7.7	8.7	10.3		
ТБҮЦ-ны ЖДХ		12.0	10.5	16.0	14.5	14.0	14.0
Бодлогын хүү		12.0	10.5	15.0	14.0	14.0	14.0
БХЗ-ын ЖДХ		12.6	11.3	15.9	15.5	14.5	14.9

\* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

\*\* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Мөнгөний нийлүүлэлт


Тухайн сард M2 мөнгөний нийлүүлэлт 3.2 хувь буюу 376.6 тэрбум төгрөгөөр өсч 12.3 их наяд төгрөгт хүрчээ. Үүнд M1 мөнгө 9.9 хувь, бусад хадгаламж, харилцах 1.9 хувиар өссөн нь нөлөөлөв.

M1 мөнгөний өөрчлөлтөд төгрөгийн харилцах 75.9 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 158.0 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.


Бусад хадгаламж, харилцахын өсөлтөд төгрөгийн хадгаламж 390.9 тэрбум төгрөг буюу 6.6 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Иргэдийн төгрөгийн хадгаламж 4.3 хувиар өссөн бол байгууллагынх 31.0 хувиар өсчээ. Сүүлийн 3 сар дараалан иргэдийн хувьд гадаад валютын хадгаламжаа төгрөгийн хадгаламжинд шилжүүлэх хандлага ажиглагдлаа. Тухайлбал банкин дахь иргэдийн гадаад валютын хугацаагүй хадгаламж 6.6 тэрбум төгрөг, хугацаатай хадгаламж 48.5 тэрбум төгрөгөөр буурсан бол төгрөгийн хадгаламж 236.9 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлтийн нөлөөг хасч тооцвол гадаад валютын хадгаламж өмнөх сараас 5.5 хувиар буурч, гадаад валютын харилцах 4.6 хувиар тус тус буурчээ.

Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн задаргаа



Зураг 2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮




Зураг 3. Хадгаламжийн үлдэгдэл (иргэд, байгууллага)



## Гадаад, дотоод актив

- Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас авч үзвэл хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 200.0 тэрбум төгрөгөөр буурч, харин дотоод цэвэр актив 576.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Гадаад цэвэр активын өөрчлөлтөд Төв банкны гадаад актив 162.5 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагуудын гадаад пассив 110.5 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.
- Хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр авлага өмнөх сараас 504.1 тэрбум төгрөгөөр буурч 17.6 их наяд төгрөг болжээ. Үүнд хувийн хэвшлээс авах авлага 134.9 тэрбум төгрөг, Засгийн газраас авах цэвэр авлага 300.6 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлөв. Харин иргэдээс авах авлага өмнөх сараас 74.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Тайлант сард нөөц мөнгө 94.5 тэрбум төгрөгөөр өсч 2933.6 тэрбум төгрөг болжээ. Хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 158.0 тэрбум төгрөг, банкуудын касс дахь мөнгө 49.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж 112.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 4. Хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив



Зураг 5. Нөөц мөнгө



Санхүүгийн байгууллагын зээл

Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 301.1 тэрбум төгрөгөөр өсч 16.7 их наяд төгрөг болжээ.


Зээлийн өсөлтийн 203.9 тэрбум төгрөг нь банкуудын зээлийн өсөлт байсан бол 97.2 тэрбум төгрөг нь бусад санхүүгийн байгууллагын (голчлон МИК ОССК)-ын зээлийн өсөлт байна.

Энэ оны 2 дугаар сарын эцсийн байдлаар санхүүгийн байгууллагуудын зээлийн 75.5 хувийг хадгаламжийн байгууллагууд, 24.5 хувийг бусад санхүүгийн байгууллагуудын олгосон зээл бүрдүүлж байна. Нийт зээлийн 48.7 хувийг иргэдэд, 44.0 хувийг хувийн хэвшилд, 7.2 хувийг улсын байгууллагуудад олгожээ.


Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 0.3 нэгж хувиар өсч 10.5 хувь болжээ. Харин чанаргүй зээлийн хувь өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурч 7.3 хувьд хүрэв. Хугацаа хэтэрсэн зээлийн 72.9 хувь, чанаргүй зээлийн 70.7 хувь нь хэвшилд олгосон зээл байна.

Харин хадгаламжийн байгууллагуудын нийт зээлийн хувьд хугацаа хэтэрсэн зээл 8.3 хувь, чанаргүй зээл 8.5 хувийг эзэлж байна. Татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 7.0 хувийг эзэлж байна.

Зураг 6. Санхүүгийн байгууллагуудын зээл



Зураг 7. Санхүүгийн байгууллагын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



Мөнгөний зах

Тухайн сард банкууд банк хоорондын захаар дамжуулан 702.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүний 64.5 хувийг овернайт зээл, 15.9 хувийг Төв банкны үнэт цаасны арилжаа, 11.7 хувийг репо арилжаа 7.9 хувийг банк хоорондын хадгаламж тус тус бүрдүүлжээ.

Банкууд 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2 дугаар сарын 28-ны өдрийн хооронд заавал байлгах нөөцийн шаардлага хангах зорилгоор 4044.4 тэрбум төгрөгийг Монголбанк дахь харилцах дансандаа байршуулжээ.

Зураг 8. Банк хоорондын захын арилжааны дүн, хүү




Хүү

Мөнгөний бодлогын зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар Бодлогын хүүг 14.0 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргасан.

Тайлант сард төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 0.1 нэгж хувиар буурч 13.3 хувь болжээ. Харин гадаад валютын хадгаламжийн хүү төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд 6.0 хувь байна. Тайлант сарын эцэст төгрөгийн харилцахын хүү 2.8 хувь, валютын харилцахын хүү 1.8 хувь байна.

Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж жилийн хүү өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурч 20.1 хувь болов. Харин зээлийн үлдэгдлээр жигнэсэн дундаж зээлийн хүү өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд 18.6 хувь байна.

Зураг 9. Хүү



Валютын ханш

Тайлант сарын эцэст Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 0.5 хувь буюу 11.4 төгрөгөөр суларч 2470.8 болжээ. Тухайн сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2478.3 төгрөг байв. 2017 оны 2 дугаар сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 2617.8, Хятадын юаньтай харьцах ханш 359.6, ОХУ-ны рубльтай харьцах ханш 42.6 байв.

Тайлант сард төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 0.5 хувиар буурсан буюу төгрөгийн гадаад валюттай харьцах ханш энэ хэмжээгээр суларсан байна.


Зураг 10. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индекс, 2010.12.31 = 100



Инфляци

2017 оны 2 дугаар сарын инфляци УБ хотын хэмжээнд 0.8 хувь байсны 0.6 нэгж хувийг хүнсний барааны үнийн өөрчлөлт, 0.2 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт эзэлж байна. Харин хүнсний барааны үнэ өмнөх сараас 2.1%-иар өсч, үүнд сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 4.6%, махны үнэ 3.9%-иар өссөн нь голлон нөлөөлөв. Хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ 0.3%-иар өсөв. Үүнд орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 1.2 хувиар өссөн нь гол нөлөө үзүүлжээ. (Орон сууцны бохир устай холбоотой зардал өмнөх сараас 61%-иар өсчээ.)

Зураг 11. УБ хотын сарын инфляци



Сарын инфляцийн 0.7 нэгж хувийг дотоодын, 0.1 нэгж хувийг импортын барааны инфляци бүрдүүлсэн байна.

Жилийн инфляци УБ хотын хэмжээнд 2017 оны 2 дугаар сарын байдлаар 1.4 хувь гарсны 0.3 нэгж хувийг хүнсний бараа, бүтээгдэхүүн, 1.1 нэгж хувийг хүнснээс бусад бараа бүтээгдэхүүн бүрдүүлж байна.

Жилийн инфляцийн 1.2 нэгж хувийг дотоодын бараа, үйлчилгээ, 0.2 нэгж хувийг импортын бараа, үйлчилгээ бүрдүүлж байна.

Зураг 12. Улсын жилийн инфляци

